



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2025 он

# ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны 12 дугаар сарын  
10-ны өдөр

Улаанбаатар  
хот

## Нэг. Хяналт-шинжилгээний зорилго

Төсөл, арга хэмжээний суурь нөхцөл байдал, хэрэгжилтийн явц, үйл ажиллагааны зорилт, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор төсөл, арга хэмжээний үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ

## Хоёр. Хяналт-шинжилгээний хамрах хүрээ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын /цаашид “нийтлэг журам” гэх/ 11.3.3 дахь заалт болон Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг үндэслэн Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа дараах төсөлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Үүнд

1. Соёлын өвийн үндэсний төвөөс хэрэгжүүлж буй Соёлын биет бус өвийг хамгаалах, чадавхыг бэхжүүлэх, үндэсний сургагч багш бэлтгэх төсөл;
2. Кино урлагийн зөвлөлөөс хэрэгжүүлж буй Монголын кино урлагийн салбарын суурь судалгаа төсөл;
3. Үндэсний номын сангийн хэрэгжүүлж буй Төвд хэлт ном, судрыг каталогжуулан цахимжуулах төсөл;
4. Уран зургийн галерейд хэрэгжсэн Гал түймэрт өртөж гэмтсэн уран зургийг сэргээн засварлах лаборатори байгуулах төсөл.
5. Чингис хаан Үндэсний музей нь дараах 2 төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:
  - “Музейн боловсролын хөтөлбөрт тэгш хамруулахад зориулсан тоног төхөөрөмжийг авах” төсөл
  - “Чингис хаан Үндэсний музейн дижитал контент хөгжүүлэлт болон үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх” төсөл
6. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хооронд 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Хөгжлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх “Мэргэн Тоньюкук музей” цогцолборын төсөл
7. Монголын аялал жуулчлалын сургалтын төв байгуулах, салбарын хүний нөөцийн чадавхын бэхжүүлэх төсөл

8. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Тогтвортой аялал жуулчлал” төсөл.

Дээрх төслүүдийн мэдээлэл, гэрээ, тайлан, нотлох баримтыг ХШУДАГ-ын даргын 2025 оны 12/277 тоот албан бичгээр харьяа байгууллагуудаас авч нийтлэг журмын 6.2 аргачлалаар үнэлэв.

### Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдэд үнэлгээ хийхэд дараах нөхцөл байдалтай байна.

#### 1. Соёлын өвийн үндэсний төвөөс хэрэгжүүлж байгаа төслүүдэд хийсэн ХШҮ-ний дүн.

Соёлын биет бус өвийг хамгаалахад оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг сайжруулах, нэмэгдүүлэх нэн шаардлагатай болсон энэ цаг үед ЮНЕСКО-ийн Ази, Номхон далайн бүсийн Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв (CRIHAP)-ийн санхүүжилтээр Соёлын өвийн үндэсний төвөөс дараах төслүүдийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1

№	Төслийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Хэрэгжүүлэх хугацаа	Төслийн үнэлгээ	Гэрээний хугацаа
1.	Монгол-Улсын соёлын биет бус өвийг хамгаалах, чадавхыг бэхжүүлэх, үндэсний сургагч багш бэлтгэх сургалт-II дахь шат-CRIHAP	5/24/2024	1 сар	100%	6/24/2024
2.	"Соёлын өвийн оршин тогтнох чадвар, тогтвортой хөгжил, соёлын өвийн бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлалд оруулах хувь нэмэр, нөөц даацыг тандан судлах"-№4500516271	8/15/2024	4 сар	100%	12/31/2024
3.	"Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх"-№4500520938	10/17/2024	9 сар	Хүлээгдэж байгаа	6/30/2025
4.	Монгол Улсын соёлын биет бус өвийг түгээн сурталчлах бие даасан цахим талбар хөгжүүлэлт-ЮНЕСКО	11/28/2024	11 сар	Хүлээгдэж байгаа	10/30/2025

Монгол орны байгаль цаг уур, газар нутгийн онцлогтой уялдан бий болсон, Монголын ард түмний уламжлалт сэтгэлгээ, ахуй амьдрал, шүтлэг бишрэл, зан заншил, мэдлэг, арга ухааны илэрхийлэл болсон соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг бэхжүүлэх, хамгаалахад оролцогч талууд чухал хувь нэмэртэй билээ. Соёлын биет бус өвийг хамгаалахад оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг сайжруулах, нэмэгдүүлэх нэн шаардлагатай болсон энэ цаг үед ЮНЕСКО-ийн Ази,

Номхон далайн бүсийн Соёлын биет бус өвийн олон улсын сургалтын төв (CRIHAP)-ийн санхүүжилтээр Соёлын өвийн үндэсний төвөөс “Монгол Улсын соёлын биет бус өвийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх” төслийн 1, 2 дугаар шатыг хэрэгжүүлжээ.

Уг төсөлд 2023 онд 12,805 ам.долларын санхүүжилтээр нийслэл, 21 аймгийн соёл, урлагийн газар, номын сан, музей, соёлын төвийн 41 албан хаагч, 2024 онд 13,750 ам.долларын санхүүжилтээр 46 албан хаагчийг тус тус хамруулж, Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын үндсэн зарчим, суурь ойлголт, хамгаалалтын механизмын талаарх ойлголт, мэдлэгийг өгч, амжилттай хэрэгжүүлсэн байна.

Сургалт бүрийн хэрэгжилтэд санхүүжүүлэгч тал хяналт тавьж ажиглагчаар оролцдог бөгөөд сургалт бүрийн дараа оролцогчдоос үнэлгээ авахад цаг үеэ олсон, хэрэгцээнд тулгуурласан, дадлага ажил, онолын мэдлэгийг хослуулан чадавхжуулж байгаа сургалт гэж үнэлжээ. Санхүүжүүлэгч талаас уг төслийн хэрэгжилтийг шаардлага хангасан гэж дүгнэсэн байна.

Уг төслийн хүлээгдэж байгаа үр нөлөөгөөр Юнеско-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын хэрэгжилтийг хангах, Монгол Улсын соёлын бие бус өвийн тогтвортой хөгжлийг дэмжих, амьд өвийг хамгаалах мэргэшсэн боловсон хүчин, үндэсний сургагч багш, чиглүүлэгч нарын сүлжээг бий болгоход хувь нэмэр оруулах үүргээ гүйцэтгэжээ.

Соёл, урлагийн салбарын ажил эрхлэлт тогтвортой бус байгаа нь сургалтын үр дүнд шууд нөлөөлж байна. Сургалтад хамрагдсан албан хаагчид гурван шатны сургалтад бүрэн хамрагдахгүй байх эрсдэл үүссэн.

2024 оны сургалтад сургалтад аймгийн соёл, урлагийн газрын мэргэжилтэн 31, музейн ажилтан 7, номын сангийн ажилтан 4, соёлын өвийн бүртгэл мэдээллийн санч 4 нийт 46 албан хаагч хамрагдсан бөгөөд өмнөх оноос 6 хүн солигдсон байна.

Оролцогчид идэвх санаачилга, хичээл зүтгэл гаргаж, багийн ажилд хариуцлагатай хандаж, сургагч багшийн арга зүйгээс анхааралтай суралцаж байгаа зэрэг нь уг сургалтын хэрэгцээ шаардлага, ач холбогдол өндөр байгааг илэрхийлж байна. Мөн орон нутгаас ирсэн оролцогчид соёлын бие бус өвийн талаар мэдлэг, ур чадвар сайн байгаа нь тэдний өмнөх сургалтаар олж авсан мэдлэг, туршлага, арга барилыг сайтар эзэмшиж орон нутагтаа хийж хэрэгжүүлсэн ажлын талаараа танилцуулж байгаа нь сургалтын үр дүнг харуулж байна.

Уг төсөл нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1.2 дахь зорилт болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.2. дахь зорилттой нийцэж байна.

## **2. Кино урлагийн зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа Монголын кино урлагийн салбарын суурь судалгаа төсөлд хийсэн ХШҮ-ний дүн.**

Монгол Улсын кино урлагийн салбарын нөхцөл байдал, нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тодорхойлох, статистикийн мэдээлэл гаргах, бүртгэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны мэдээлэлд үндэслэн цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах зорилгоор Кино урлагийн зөвлөлөөс “Монголын кино урлагийн салбарын суурь судалгаа” төслийг Юнеско-Ашбергийн хөтөлбөрийн 30,000 ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлсэн байна.

Уг төслийг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулж 9 сарын хугацаанд гэрээний дагуу дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- МУИС-ийн судалгааны байгууллагатай судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан.

- Уран бүтээлчдийн статус тодорхойлох, чадавхжуулах сургалт семинар зохион байгуулсан.
- Кино урлагийн салбарын суурь судалгааны дата сан үүсгэх ажлыг ММСГ, Монгол кино уран бүтээлчдийн статусыг тодорхойлох судалгааны ажлыг Модун хөгжлийн төв ТББ, Кино уран бүтээлчдийн статустай холбогдож баримт бичгийн судалгааны ажлыг Хөгжлийн санаачилга бодлого судлалын төв ТББ-аар тус тус хийгдэж дууссан.
- Судалгааны урьдчилсан тайланг Юнескод танилцуулсан.
- Судалгааны тайланг салбарын уран бүтээлчдэд тайлагнасан.

Одоогийн байдлаар судалгааны ажлын тайланг англи, монгол хэлээр хэвлүүлэх ажил хийгдэж байгаа тул төслийн үнэлгээ 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

### **3. Монгол Улсын Үндэсний номын сангаас хэрэгжүүлсэн Төвөд хэлт ном, судрыг каталогжуулан цахимжуулах төсөлд хийсэн ХШҮ-ний дүн.**

Дотоодын болон гадаадын судлаачдын хүрч уншиж судлахад хүндрэлтэй байдаг ном, судрыг нээлттэй болгоход чиглэсэн мөн орчны нөлөөнөөс үүдэн элэгдэн хорогдож, гэмтэх эрсдэлд байгаа төвөд судруудыг хадгалан хамгаалах зорилгоор 2018 онд БСШУЯ-ны зөвшөөрлийг үндэслэн Азийн өвийн сантай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан Үндэсний номын сангаас Төвөд хэлт ном, судрыг каталогжуулан цахимжуулах төслийг хэрэгжүүлж байна.

Уг төслийн хүрээнд Үндэсний номын санд хадгалагдаж байгаа төвөд хэлт судруудаас 2,480,401 хуудас буюу 8,223 баринтаг судар цахимжуулан, 156,733 гарчиг судар олон улсын бүртгэлийн стандартын дагуу каталог хийсэн. Үндэсний номын сангаас веб сайтад тавьсан 8,000 орчим төвөд судрууд дэлхийн 71 орны уншигчдад хүрсэн байна. Веб сайтад байршсан судрууд 1 сард дунджаар 127,661 хандалт авсан байна. Төсөлд ажиллаж байгаа болон ажиллаж байгаад гарсан нийт 16 хүн төвөд хэлт ном судрыг хэрхэн цахимжуулах, галиглан бүртгэх тал дээр мэргэжилтэн болж бэлтгэгдсэн ач холбогдолтой байна.

Каталогжуулан цахимжуулах үйл ажиллагааны үр дүнд үүссэн цахим датаг Азийн өвийн сангийн цахим номын сан /<https://asianlegacylibrary.org/library/portal/#/> болон Буддын цахим өвийн төвөөр /<https://libraray.bdrc.io/> дамжуулан уншигчдад үнэ төлбөргүй хүргэдэг бөгөөд ингэснээр олон улсын эрдэмтэн, судлаач, орчуулагч, оюутнуудад түгээх хүртээмж нэмэгдэх нөхцөл бүрдсэн гэж хяналт-шинжилгээ, үнэлгээгээр дүгнэв.

Төслийн гэрээний хугацаа 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр дуусах тул цаашид Төвөд судрын бүртгэлийн ажлыг үргэлжлүүлэх төсөв шаардлагатай байна.

#### **4. Уран зургийн галерейгаас хэрэгжүүлсэн “Гал түймэрт өртөж гэмтсэн уран зургийг сэргээн засварлах лаборатори байгуулах” төсөлд хийсэн ХШҮ-ний дүн.**

Монгол Улсад анх удаа олон улсын жишигт нийцсэн сэргээн засварлалтын лабораторийг байгуулж, Монголын Уран зургийн галерейн сан хөмрөгт хадгалагдаж буй галд өртөж гэмтсэн уран зургуудыг мэргэжлийн өндөр түвшинд засварлах, түүнчлэн мэргэжлийн сэргээн засварлагчдыг бэлтгэх зорилгоор уг төслийг хэрэгжүүлжээ.

ХБНГУ-ын Гадаад хэргийн яамны Соёлын өвийг хадгалан хадгалан хамгаалах, хөтөлбөрийн буцалтгүй 100,000 еврогийн тусламжаар Монгол Улсын хэмжээнд олон улсын стандартад нийцсэн анхны уран зураг сэргээн засварлах лабораторийг Уран зургийн галерейн дэргэд 2020-2023 онд амжилттай байгуулж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Монголын Уран Зургийн Галерейн дэргэд “Уран зураг сэргээн засварлах лаборатори байгуулах” төслийг дараах үе шаттайгаар 100 хувь бүрэн хэрэгжүүлсэн.

Уран зураг сэргээн засварлах лабораторийн санхүүгийн төлөвлөгөөний дагуу лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий 70,000 еврогийн 2 удаагийн худалдан авалтыг хийж олон улсын стандартын шаардлагад бүрэн нийцсэн иж бүрэн лабораторийг байгуулсан. Уг худалдан авсан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нь олон улсын стандартад нийцсэн чанар үзүүлэлт хүчин чадал нь өндөр бөгөөд уран зураг сэргээн засварлах халдаг ширээ нь Монгол улсын хэмжээнд хамгийн том, үзүүлэлт өндөр ширээ болж байгаа юм.

Монголын Урлагийн зөвлөл, Эм Си Эс группийн 88 сая төгрөгийн санхүүжилтээр лабораторийн засвар тохижилтыг хийсэн.

Төслийн 3 шатлалт сургалтыг зохион байгуулах герман мэргэжилтний сонгон шалгаруулалтыг зарлаж ХБНГУ-ын 3 мэргэжилтэн санал ирүүлснээс ажлын хэсэг хатагтай Сузанне Эрхардсийг сонгон шалгаруулж ажиллуулсан.

Эхний хэсгийн 16 өдрийн 128 цагийн сургалтаар уран зураг сэргээн засварлах лабораторийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийн хэрхэн ашиглах, туршилтын уран зургийг хэд хэдэн янзаар шатааж зураг шатах үйл явцтай танилцаж туршилт хийсэн. Г.Машбатын “Уурхайн өвөл” уран зургийг сэргээн засварлаж эхэлсэн.

Хоёр дахь хэсгийн 12 өдрийн 96 цагийн сургалтаар уран зургийн өнгө будгийн шинж чанар найрлагыг судалж, суралцагчид өөрсдөө будаг найруулах, өнгө будгийн нөхөлт хэрхэн хийх, нөхөлтийн материал бэлтгэж, Г.Лхагвасүрэнгийн “Түмний эх” бүтээлд шинжилгээ хийж зотон хуулбар дээр ажилласан. Уран зураг сэргээн засварлахад дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хэд хэдэн арга барилаас суралцсанаас XVIII зууны сэргэн мандалтын үед өргөнөөр хэрэглэж байсан “Траттежио” уран зураг, түүний сэргээн засварлах уран зургаас суралцсан хамгийн чухал ач холбогдолтой байжээ.

Сүүлийн хэсгийн 18 өдрийн 144 цагийн сургалтаар халдаг ширээг хэрхэн ашиглаж уран зураг сэргээн засварлах, нөхөлт хийх онол практик хосолсон мэдлэгийг эзэмшүүлсэн.

Энэхүү 3 удаагийн сургалтын үр дүнд суралцагч нар олон улсын хөтөлбөрөөр мэргэшин бие даан уран зураг сэргээн засварлаж Монгол Улсын

соёлын өвийг авран хамгаалах ажилд бодитой хувь нэмэр оруулах дэлхийн хэмжээний уран зураг сэргээн засварлах сэргээн засварлагч нар бэлтгэгдэн гарсан.

Уран зураг сэргээн засварлах лабораторийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах ажлын хүрээнд НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР"-г зохион байгуулж 300 гаруй үзэгч Монголын анхны уран зураг сэргээн засварлах лабораторийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, галд гэмтсэн урлагийн бүтээлийн сэргээн засварлалтын үйл явцтай танилцсан.

Төслийн тухай 30 минутын бүрэн хэмжээний баримтат нэвтрүүлэг бэлтгэж Монголын үндэсний телевиз болон MNC сувгаар олон нийтэд цацсан. Мөн уг төслийн тухай каталогийг Монгол, Англи хэлээр эрхлэн гаргажээ.

Тус лабораторид 2023 онд Л. Гаваа “Цахилгаан” уран зураг, Г. Одон “Ээж хайрхан” уран зураг, С. Энх – Амгалан “Говь” уран зураг, Ц. Жамсран “Гурван улиас” уран зураг, С. Даринчулуун “Анхны дүн” уран баримал, 2024 онд Г. Машбат “Уурхайн өвөл”, Д. Пүрэвдорж “Зандраа хөрөг”, Ч. Чулуун “Натюрморт” бүтээлүүдийг сэргээн засварлаж үзэсгэлэнд дэглэсэн үр дүнд хүрсэн.

#### **5. Чингис хаан Үндэсний музей нь дараах 2 төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:**

- Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкагаас 97,500,000 иений буцалтгүй тусламжаар “Музейн боловсролын хөтөлбөрт тэгш хамруулахад зориулсан тоног төхөөрөмж”-ийг авах төсөл 2024 оны 10 дугаар сарын 3-ны өдөр “Ноот бичиг” хоёр улсын Засгийн газраар зурагдаж баталгаажсан. 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр “Зөвлөхийн гэрээ” байгуулагдаж хэрэгжилтийн шат руу шилжээд байна.
- Бүгд Найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Койкагаас 6 сая долларын буцалтгүй тусламжаар “Чингис хаан Үндэсний музейн дижитал контент хөгжүүлэлт болон үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн урьдчилсан болон нарийвчилсан судалгааг дуусгаж 2025 оны 3 дугаар сард Засгийн газар хоорондын “Ноот бичиг” байгуулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл хангаж ажиллаж байна.

#### **6. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хооронд 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Хөгжлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх “Мэргэн Тоньюкук музей” цогцолборын төсөлд хийсэн ХШҮ-ний дүн.**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хооронд 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Хөгжлийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг байгуулсан. Улмаар 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр нийслэлийн Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших Тоньюкукын цогцолбор дурсгалыг түшиглэн Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /ТИКА/, Монгол Улсын Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам хооронд байгуулсан “Мэргэн Тоньюкукийн музейн барилга угсралт, гадаад орчны тохижилт

болон музейн үзэсгэлэнгийн танхимын тохижилтын төсөл”-ийг хэрэгжүүлэх буцалтгүй тусламжийн хэлэлцээр байгуулсан.

Хэлэлцээрийн дагуу төслийг Монгол Улсын Засгийн газар буюу Соёлын яам нь Засгийн газрын 2002 оны 71 дүгээр тогтоолоор баталсан Тоньюкукын цогцолбор дурсгалын 65.58 кв.км (6558 га) хамгаалалтын бүс дотор нийт 20 га талбайд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Нийт 20 га газарт төлөвлөсөн тус бүтээн байгуулалт нь 1.Музей, түүний дагалдах барилга байгууламжийн бүс, 2.Музейг даган хөгжих худалдаа үйлчилгээний бүс, 3.Амралт зугаалгын бүс гэсэн 3 бүсэд хэрэгжих юм.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Мэргэн Тоньюкукийн музейн цогцолборыг төвийн бүсийн түүх, соёлын аялал жуулчлалын маршрут /Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг хөшигийн олон улсын нисэх буудал/, /Зуунмод суманд байгуулах Монголын үндэсний археологи, угсаатны музей, лаборатори/, /Сэргэлэн сумын нутагт байгуулах Майдар хот/, /Эрдэнэ сумын нутаг Чингис хааны морьт хөшөөт цогцолбор/, /Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар/-д оруулж, хөгжүүлэхээр зорьж байна.

1. Музей, түүний дагалдах барилга байгууламжийн бүсэд музейн барилга, 2 давхар оффисын барилга, ажилчдын байр, техникийн барилга, харуулын байр барихаар төлөвлөж байна. Үүнд: музейн барилгад үзэсгэлэнгийн танхим, мэдээлэл хүлээлгийн хэсэг, музейн бэлэг дурсгалын дэлгүүр, кофе шоп, хүүхдийн тоглоомын өрөө, оффисын өрөө, хурлын танхим, душ, ариун цэврийн өрөө, техникийн өрөө болон агуулах. Ажилчдын байранд зочны өрөө, гал тогоо, унтлагын өрөө, ариун цэврийн өрөө. Техникийн барилгад техникийн ажилтны өрөө, механикийн өрөө, техникийн өрөө, дулааны узель, агуулах, ариун цэврийн өрөө. харуулын байранд харуулын өрөө, ариун цэврийн өрөө зэрэг барихаар төлөвлөөд байна.

2.Музейг даган хөгжих худалдаа үйлчилгээний бүс нь олон нийтийн түүх, соёлын дурсгалын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тухайн үеийн түүхийг худалдаа болон үзвэр үйлчилгээ, хоолны газрууд зэрэг соёлын олон талт шингэсэн хэлбэрээр таниулан сурталчлах, хөгжүүлэх ач холбогдолтой юм.

3.Амралт зугаалгын бүс нь Мэргэн сайд Тоньюкукийн дурсгалын иж бүрдэл, ойр орчмын дурсгалын тархцад түшиглэн алхаж зугаалангаа ойр орчмын дурсгалтай танилцах, ил байдлаар үзэж сонирхох боломжийг бүрдүүлэн орчныг тохижуулж, амралт зугаалгын чиглэлээр хөгжүүлэх юм.

Ийнхүү “Мэргэн Тоньюкук музей” соёл, аялал жуулчлалын цогцолборыг 3 хэсэгт бүсчлэн төлөвлөлтийн дагуу байгуулснаар түүх, соёлын өвийг хадгалж хамгаалах чиглэлд жишиг бүтээн байгуулалт болохоос гадна тухайн бүс нутгийн иргэд ажлын байраар хангагдах, газар ашиглалтын оновчтой шийдэл зэрэг бүс нутгийн хөгжлийг шинэ шатанд хүргэнэ. Мөн төлөвлөлтгүй барилгажих, хамгаалалтын бүсийн дэглэм алдагдах, түүх, соёлын дурсгал бүхий үнэ цэнтэй бүс нутгийг доройтуулах зэрэг эрсдэлээс сэргийлэгдэнэ.

Засгийн газрын 2002 оны 71 дүгээр тогтоолоор баталсан Тоньюкукын цогцолбор дурсгалын 65.58 кв.км (6558 га) хамгаалалтын бүс нь нийслэлийн Налайх дүүргийн 3 дугаар хороо болон Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт дамнан орших ба хилийн цэс орчмын маргаантай байдаг.

Соёлын сайдын 2020 оны А/77 дугаар тушаалаар “Мэргэн Тоньюкукийн музей” цогцолборын барилга барих газрын асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх



зорилгоор ажлын хэсгийг байгуулан ажиллан, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн хүсэлт тавьсны үр дүнд Налайх дүүргийн Засаг даргын 2021 оны А/58, А/87 дугаар захирамжаар 20 га газрын асуудлыг шийдвэрлэсэн хэдий ч газрыг Налайх дүүргийн Засаг дарга нь тус дүүргийн тамгын газарт эзэмшүүлсний улмаас барилгын техникийн нөхцөл болон холбогдох зөвшөөрөл авахад газар эзэмшигч нь захиалагч байгууллага байх шаардлагатайн улмаас хүндрэлтэй асуудлууд тулгарч, 20 га газрыг захиалагч байгууллага болох Соёлын яамны нэр дээр шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг Налайх дүүргийн Засаг даргад удаа дараа буюу 2021 оны 5 удаа хүргүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй.

Улмаар Соёлын яамны зүгээс энэ асуудлаар 20 га газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, Соёлын яамны нэр дээр шилжүүлж өгөх тухай хүсэлтийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд гаргасан ба Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/202 дугаар захирамжаар дээрх төслийн 20 га газрыг Соёлын яамны нэр дээр эзэмшүүлсэн.

Төслийн хүрээнд барилгажих 7га газарт хэрэгжүүлэх 4 (музейн барилга, ажилчдын орон сууц, техникийн барилга, харуул хамгаалалтын барилга) бүтээн байгуулалтын зураг төслийг Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /ТИКА/-аас ирүүлсэн ба Монгол улсын хууль тогтоомжийн дагуу барилга норм, стандартад нийцүүлэх, барилга угсралт, гадаад орчны тохижилтын ажлын зураг төсвийг “Некст степ инженеринг” ХХК-иар гүйцэтгүүлэн, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /ТИКА/-т хүлээлгэн өгсөн.

Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг /ТИКА/ нь зураг төслийг хянан шалгаж, БНТУ-ын хууль тогтоомжийн дагуу ерөнхий гүйцэтгэгчээр “Эйч Эн Си констракшн” ХХК-ийг шалгаруулан, 5,795,000 ам долларын гэрээг байгуулж, барилгын ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Мөн 2024 онд төслийн нэмэлт ажилд зориулан гэрээний үнийн дүнгийн 20,19%-тай тэнцэх дүн буюу 1,169,756.47 ам долларын санхүүжилтийг гүйцэтгэгчийн гэрээнд тусгаад байгаа бөгөөд 2025 оны байдлаар төслийн явц 80 хувьтай хэрэгжиж байна.

## **7. Монголын аялал жуулчлалын сургалтын төв байгуулах, салбарын хүний нөөцийн чадавхын бэхжүүлэх төсөлд хийсэн ХШҮ-ний дүн.**

Уг төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, спорт аялал жуулчлалын яамны харьяа Аялал жуулчлалын төрийн өмчит корпорацаас 5.5 тэрбум воны тусламжаар 2019-2024 онд хэрэгжүүлсэн. Аялал жуулчлалын сургалтын төв нь нийт 2739.8 м<sup>2</sup> талбайтай бөгөөд Хан-Уул дүүргийн Арцатын задгайд байрлалтай. 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс ажилласан.

Сургалт, дадлагын төв байгуулагдсанаар аялал жуулчлалын салбарын боловсон хүчин бэлтгэх үндсэн үйл ажиллагаанаас гадна Монгол Улсад зочлох Солонгос жуулчдад үйлчлэх мэдээллийн төв, хоёр улсын оюутан залуусын хамтын ажиллагааг өргөжүүлэх төв зэргээр өргөн хүрээний үйл ажиллагааг явуулах, Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний чадавхыг бэхжүүлж, зочлох үйлчилгээний салбарын ажилтны ур чадвар олон улсын хэмжээнд хүрэх боломж бүрдэнэ.

Мөн Зочлох үйлчилгээний 10 мэргэжил болох хөтөч тайлбарлагч, зочин хүлээн авагч, зөөгч, бариста, бартендер, тогооч, хаалгач, ачаа зөөгч, өрөөний болон

гэрийн үйлчлэгч, жолооч гэсэн мэргэжлээр сургалтыг явуулж, жилд шинээр 850-2600 хүн, давтан сургалтад 1800-5700 хүнийг хамруулан, нийт 50-70 гаруй хүн ажлын байраар хангагдана.

## **8. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Тогтвортой аялал жуулчлал” төсөлд хийсэн ХШҮ-ний дүн.**

Азийн хөгжлийн банк 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Зээл 3787/3788-МОН: Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамд шилжүүлсэн. Уг төсөл нь тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх үндэсний загварыг бий болгох, төсөл хэрэгжиж буй орон нутгийн байгаль хамгаалал, аялал жуулчлал, эдийн засгийн асуудлыг цогцоор шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд 4 зорилтын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

### **1. Нутгийн оршин суугчдад түшиглэсэн хүртээмжтэй аялал жуулчлалын төлөвлөлт болон чадавхыг сайжруулах**

- “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолборын /ЧХАЖЦ/ менежментийн байгууллага байгуулах талаарх судалгаа хийж, зөвлөмж танилцуулсан.
- ЧХАЖЦ-ын аяллын маршрутыг сурталчлах зөвлөх үйлчилгээний тендер зарлаж, сонгон шалгаруулалт хийгдэж байна. Олон нийтийн санаачилгаар төлөвлөж хэрэгжүүлэх аялал жуулчлалын жижиг арга хэмжээ, төсөлд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд нийт 4 багц гэрээний тендер зарлаж, сонгон шалгаруулан, гэрээ байгуулж, гүйцэтгэлийн ажлуудыг эхлүүлсэн.
- Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд байгуулах Жанхайн давааны худалдааны төвд суурилуулах хяналтын камер худалдан авах 1 багц гэрээт ажил хэрэгжиж дууссан.
- Зээлийн эргэлтийн санг бэхжүүлэх зорилгоор ХНБЦГ /Хэнтийн нурууны байгалийн цогцолборт газар/-ын орчны бүсийн сумдын 500 гаруй иргэдэд бизнесийн сургалт зохион байгуулсан.

### **2. Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах**

- ХНБЦГ-т нийт 37.9 км хатуу хучилттай авто зам, 7-н авто зогсоолын ажлын хүрээнд нийт 8 км авто зам, 1 авто зогсоол, 549 м давуулах далангийн барилга угсралтын ажил хийгдсэн.
- ЧХАЖЦ-ын Авто зам болон зогсоолын зураг төсвийг боловсруулж дуусган магадлалаар батлуулсан.
- ЧХАЖЦ-ыг Дадал сумын төвтэй холбох 1.9 км авто зам болон 3-н зогсоолын гүйцэтгэгчийн тендер зарлан, сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, ажлыг эхлүүлсэн.
- ЧХАЖЦ-ын Мэдээллийн төв /БУЦБ-ийн зураг төсвийг боловсруулан магадлалаар оруулж батлуулж, интерьер дизайны зураг төсөв боловсруулах туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулан, зураг төслийг боловсруулж батлуулах ажил хийгдэж байна.
- ЧХАЖЦ-ын Мэдээллийн төвийн барилга /БУЦБ, ландшафт, гадна тохижилтын ажлын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

### 3. Хог хаягдлын менежментийг сайжруулах

- ХНБЦГ, Дадал суманд ариун цэврийн байгууламж барих гүйцэтгэгчийн тендер зарлан, сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, ХНБЦГ-ын Жанхайн даваа болон Мөрөн хотын Ариун цэврийн байгууламжийн барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн. Газар шороо болон суурийн цутгалтын ажлууд хийгдэж дууссан.
- Хөвсгөл аймаг дахь Хатгал тосгон, Ханх сумын бохир ус цэвэрлэх байгууламжийн /БУЦБ/ барилга угсралтуудын ажлыг гүйцэтгэж дуусган, Улсын комисс ажиллуулж, байнгын ашиглалтад оруулсан.
- Бохир ус цэвэрлэх байгууламжуудын ашиглагч байгууллагуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулсан.
- Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Хэнтий аймгийн Дадал сумын хатуу хог хаягдлын ландфилл байгууламжуудын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж дуусган, Улсын комисс ажиллуулж, байнгын ашиглалтад оруулсан. Ландфилл байгууламжуудад “Ашиглалт завсар үйлчилгээ”-ний гарын авлага боловсруулж, хүлээлгэн өгсөн.

### 4. ТХГ-ын менежментийг боловсронгуй болгох

- ХУТХГ-ын /Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газар/ ХЗ/Жуулчны мэдээллийн төвийн барилга угсралтын ажлын тендер сонгон шалгаруулан, гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн ба газар шороо болон суурийн цутгалтын ажил, гүний худаг гаргах, худгийн байр барих, гадна цахилгаан шугам татах, дэд станц буулгах ажлууд хийгдсэн.
- Нэвтрэх цэг, төлбөр хураах цэгийн барилга угсралтын ажил гүйцэтгэгчийн тендер сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.
- Тус ажлыг гүйцэтгэх А2: "Авто зам, зогсоолын" гэрээт ажлын хэрэгжилт удааширсан болон гэрээний үнийн дүн өсөх эрсдэлтэй байгаа тул асуудлыг шийдвэрлэх хүртэл тус ажлыг хойшлуулсан.
- "ОББЦГ-ын /Онон Балжийн байгалийн цогцолборт газар/ менежментийн төлөвлөгөө-2019-2023 он"-ий үр ашигт байдлын үнэлгээ орчны бүсийн сумдад хийсэн.
- ОББЦГ-ын Менежментийн төлөвлөгөө-2023-2032 боловсруулж, батлуулан, орон нутагт хүлээлгэн өгсөн.

### Дөрөв. Дүгнэлт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон харьяа 5 байгууллагад Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж дууссан 2, хэрэгжүүлж байгаа 5, хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа 1 төсөл байна. Төслийн дүнг нэгтгэн үзвэл дараах байдалтай байна.

№	Төслийн нэр	Төслийн хугацаа	Төслийн үнэлгээ	Хэрэгжүүлэгч байгууллагын нэр
---	-------------	-----------------	-----------------	-------------------------------

1.	Соёлын биет бус өвийг хамгаалах, чадавхыг бэхжүүлэх, үндэсний сургагч багш бэлтгэх	2024-2025	100%	СӨҮТ
2.	Монголын кино урлагийн салбарын суурь судалгаа	2024	90%	КУЗ
3.	Үндэсний номын сангийн хэрэгжүүлж буй Төвд хэлт ном, судрыг каталогжуулан цахимжуулах	2018-2025	88%	ҮНС
4.	Гал түймэрт өртөж гэмтсэн уран зургийг сэргээн засварлах лаборатори байгуулах	2022-2023	100%	УЗГ
5.	<ul style="list-style-type: none"> <li>• “Музейн боловсролын хөтөлбөрт тэгш хамруулахад зориулсан тоног төхөөрөмжийг авах” төсөл</li> <li>• “Чингис хаан Үндэсний музейн дижитал контент хөгжүүлэлт болон үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх” төсөл</li> </ul>		-	ЧХҮМ
6.	“Мэргэн Тоньюкук музей” цогцолборын төсөл	2018-2025	80%	ССАЖЗЯ
7.	Монголын аялал жуулчлалын сургалтын төв байгуулах, салбарын хүний нөөцийн чадавхын бэхжүүлэх төсөл	2019-2024	98%	ССАЖЗЯ
8.	Тогтвортой аялал жуулчлал төсөл	2019-2026	80%	ССАЖЗЯ
<b>ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ</b>			<b>90.8%</b>	

Соёлын өвийн үндэсний төвөөс хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын соёлын биет бус өвийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх” төслийн 1, 2 дугаар шатыг 2023-2024 онд 26,555 ам долларын санхүүжилтээр амжилттай хэрэгжүүлж, давхардсан тоогоор 90 албан хаагчийг хамруулж, Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын үндсэн зарчим, суурь ойлголт, хамгаалалтын механизмын талаарх ойлголт, мэдлэгийг өгч, чадавхыг бэхжүүлсэн. Энэ мэдлэг чадвараа эрхэлж буй үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж байна.

"Соёлын өвийн оршин тогтнох чадвар, тогтвортой хөгжил, соёлын өвийн бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлалд оруулах хувь нэмэр, нөөц даацыг тандан судлах" төслийн хүрээнд цахим болон танхимаар 40 хүнийг хамруулсан.

Кино урлагийн зөвлөлөөс Юнеско-Ашбергийн хөтөлбөрийн 30,000 ам долларын санхүүжилтээр 2024 онд хэрэгжүүлж байгаа “Монголын кино урлагийн салбарын суурь судалгаа” төслийг 90 хувьтай хэрэгжүүлж байна.

Үндэсний номын сангаас Төвөд хэлт ном, судрыг каталогжуулан цахимжуулах төслийг 2018 оноос БСШУЯ-ны зөвшөөрлийг үндэслэн Азийн өвийн сантай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан хэрэгжүүлж байна. Уг төсөл нь 2025 он хүртэл үргэлжлэх бөгөөд 2018-2024 онд 1,417.0 сая төгрөгийг зарцуулж, Үндэсний номын санд хадгалагдаж байгаа төвөд хэлт судруудаас 8,223 баринтаг судар цахимжуулан, 156,733 гарчиг судрыг олон улсын бүртгэлийн стандартын дагуу каталогжуулсан байна.

Төслийн хүрээнд 138.2 сая төгрөгийн 31 төрлийн 94 үндсэн хөрөнгө бэлтгэгдсэн байна.

Мөн төсөлд ажиллаж байгаа 16 ажилтан цахимжуулах, галиглах, бүртгэх тал дээр мэргэшиж, хадгалалт хамгаалалт, тоног төхөөрөмж болон техникийн ур чадвараа дээшлүүлж, салбартаа тэргүүлэх боловсон хүчин болсон байна.

ХБНГУ-ын Гадаад хэргийн яамны Соёлын өвийг хадгалан хамгаалах, хөтөлбөрийн буцалтгүй 100,000 еврогийн тусламжаар Монгол Улсын хэмжээнд олон улсын стандартад нийцсэн анхны уран зураг сэргээн засварлах лабораторийг Уран зургийн галерейн дэргэд 2020-2023 онд амжилттай байгуулж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Төслийн хүрээнд 194.4 сая төгрөгийн 25 нэр төрлийн 47 тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн.

Тус лабораторид 2023 онд 5 бүтээл, 2024 онд 3 бүтээл сэргээн засварласан үр дүнтэй байна.

“Мэргэн Тоньюкукийн музейн барилга угсралт, гадаад орчны тохижилт болон музейн үзэсгэлэнгийн танхимын тохижилтын төсөл”-ийг хэрэгжүүлэх буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан талууд харилцан тохиролцож, хэлэлцээрийн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 3 жилийн хугацаатай сунгасан хэдий ч гадаад, дотоодын худалдан авалт, бүтээн байгуулалтын бараа материал нийлүүлэлт, байгалийн давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан төслийн хугацааг дахин нэг жилээр сунгах шаардлага үүсээд байна.

Аялал жуулчлалын сургалт, дадлагын төв байгуулагдсанаар аялал жуулчлалын салбарын боловсон хүчин бэлтгэх үндсэн үйл ажиллагаанаас гадна Монгол Улсад зочлох Солонгос жуулчдад үйлчлэх мэдээллийн төв, хоёр улсын оюутан залуусын хамтын ажиллагааг өргөжүүлэх төв зэргээр өргөн хүрээний үйл ажиллагааг явуулах, Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчний чадавхыг бэхжүүлж, зочлох үйлчилгээний салбарын ажилтны ур чадвар олон улсын хэмжээнд хүрэх боломж бүрдэнэ.

Тогтвортой аялал жуулчлал төслийн Эко аялал жуулчлалын төлөвлөлтийн зөвлөх үйлчилгээний хүрээнд БОАЖЯ, Хөвсгөл, Хэнтий аймгийн ЗДТГ, Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Дадал сумын ЗДТГ, ХНБЦГ, ОББЦГ-ын Хамгаалалтын захиргаа болон орон нутгийн аялал жуулчлалын холбоодтой хамтран нийт 26 удаагийн сургалтаар орон нутгийн 2685 хүн (үүнээс 1937 нь эмэгтэй)-ийг аялал жуулчлалын зочлох үйлчилгээ, үйлчилгээний харилцаа хандлага, тогооч, менежерийн ур чадвар дээшлүүлэх зэрэг чиглэлээр сургасан. Үүнээс: 2024 онд 4 удаагийн сургалтаар 396 хүн сургасан.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны хатуу хог хаягдлын ландфилл байгууламжийн ашиглалт хариуцсан "Бор согоот" ХХК-ийн дор 6 ажлын байр шинээр үүссэн. Мөн Хэнтий аймгийн Дадал сумын хатуу хог хаягдлын ландфилл байгууламжийн ашиглалт болон сумын хог хаягдал, тохижилтын ажлыг хариуцсан "Дадал тохижилт" ХХК шинээр байгуулагдсан бөгөөд нийт 5 ажлын байр бий болсон.

### **Тав. Зөвлөмж**

Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

**Холбогдох нэгжийн даргад:**

Зөвлөмж -1: Үндэсний номын сангийн хэрэгжүүлж байгаа төслийн хувьд 2025 онд төслийн гэрээний хугацаа дуусаж байгаа тул цаашид Төвөд судрын бүртгэлийн ажлыг үргэлжлүүлэх хөрөнгийг шийдвэрлэх.

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад:**

Зөвлөмж -1: Төслийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон жил бүр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

Зөвлөмж -2: Төслийн санхүүгийн тайланг гаргаж, хөрөнгийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулах.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oOo---